



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	2
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5
<i>Горимын санал</i>	5

*Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хянан шалгах түр хороо/Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой
зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл
ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд
хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах,
иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их
Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг
бүхий/-ны 12 дугаар сарын 11-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл*

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 08 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: О.Цогтгэрэл.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт М.Мандхай нар байлцав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр Түр хорооны хянан шалгагч, шинжээч томилох асуудлуудыг хэлэлцэх учир хуралдааныг хаалттай горимд шилжүүлбэ гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжбэ гэсэн санал хураалт явуулбэ.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 2

Бүгд: 7

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 11 цаг 12 минутад хаалттай горимд шилжүүлэв.

12 цаг 44 минутад хуралдааныг нээлттэй горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 07 минут үргэлжилж, 11 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр 12 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын
15-ны өдөр, Даваа гараг Төрийн ордон
“засаг” танхим 11 цаг 08 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Гишүүдийнхээ
өдрийн амгаланг айлтгая.

Төрийн болон орон нутгийн
өмчит, өмчийн оролцоотой зарим
компаниудын нүүрс олборлолт,
борлуулалт, тээвэрлэлт, экспортын
үйл ажиллагаа болон бусад бараа,
ажил, үйлчилгээ, худалдан авалтын
үйл ажиллагаанд хяналт шалгалт
хийх, нотлох баримтыг шинжлэн
судлах, нээлттэй сонсгол зохион
байгуулах, иргэд олон нийтийг
мэдээллээр хангах, хяналт шалгалтын
тайланг Улсын Их Хурлын 2023 оны
намрын ээлжит чуулганы хугацаанд
багтаан танилцуулах үүрэг бүхий
Хянан шалгах түр хорооны 2023 оны
12 дугаар сарын 11-ний өдрийн
хуралдаан гишүүдийн олонх хүрэлцэн
ирсэн тул нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн хуралдаанаар 2
асуудал хэлэлцэнэ.

1.Хянан шалгах түр хорооны
сонсголд гэрчээр дуудах тухай Түр
хорооны тогтоолын төсөл,

2.Нотлох баримт гаргуулах
тухай 2023 оны 11 дүгээр сарын 22-
ны өдрийн 17 дугаар тогтоолд
нэмэлт оруулах тухай тогтоолын
төслийг хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай
холбоотой саналтай гишүүн байна
уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе оо.
Хэлэлцэх асуудлууд нь Түр хорооны
дотоод асуудал учраас Монгол Улсын
Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуулийн 12 дугаар
зүйлийн 12.2, 12.3 Монгол Улсын Их
Хурлын тухай хуулийн 22.2 дахь
хэсэгт заасныг үндэслэн хаалттай
хуралдах горимын санал гаргаж
байна.

Горимын саналыг дэмжье гэдэг
саналын томъёоллоор санал хураалт
явуулъя.

Санал хураалт 71.4 хувийн
саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдааныг хаалттай горимд
шилжүүлье.

Баярлалаа хэлэлцэх асуудал
дууссан тул хуралдааныг нээлттэй
горимд шилжүүлье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА